

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

200... он ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Үнэт цаасны зах зээл дээр брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулж байгаа “БИДИСЕК” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тухай, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж нарын үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийг сэргээх хүсэлтийн тухай асуудлыг Үнэт цаасны газрын ахлах мэргэжилтэн Л.Энхбаяр танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“БИДИСЕК” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцээд дор дурдсан 2 асуудлаас бусад үүргийг биелүүлсэн гэж үзэв.

1. “Монбайгаль” ХХК нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлсэн эсэх, эрхэлсэн гэж үзвэл холбогдох хөрөнгийг “БИДИСЕК” ХК-д шилжүүлсэн эсэх, зохих татварыг төлсөн эсэхийг сарын хугацаанд тодруулж танилцуулах.

2. Д.Данзангийн дансанд хийсэн “Дархан хөвөн” ХК-ийн 9924 ширхэг хувьцааг компанийн нэр дээр шилжүүлж, “БИДИСЕК” ХК-ийн өмчлөлд шилжүүлэх. Уг асуудлыг тогтоол хэлбэрээр шилжүүлэхээр тогтов.

3. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байдлыг харгалзан үзэж Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж нарын үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийг сэргээх арга хэмжээ авахаар тогтов.

4. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, аливаа шинэ харилцааг төлөвшүүлэх, зохицуулагдаагүй асуудлаар шийдэл гаргахдаа урьдчилж тус Хороонд мэдээлэн ажиллах, хувьцаанд хөрвөх нөхцөл бүхий зээл олгосон тухай асуудлаа эргэж Үнэт цаасны газар тайлагнахыг “БИДИСЕК” ХК /Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн/-д үүрэг болгохоор тогтов.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Х.БУМ-ЭРДЭНЭ